



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цаг уур, орчны шинжилгээний газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000421

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн
433 дугаар тогтоолын хавсралт



Эрчим хүчний яамны балансаас

Цаг уур, орчны шинжилгээний газрын балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт 6099169 1118262983

Д/д	Автомашинны төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Ниссан Теана", 33-46 УБЗ, суудлын	2008.02.15	150787	37,173,580.00	37,173,580.00	0
НИЙТ ДҮН:						
				37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян)	37,173,580.00 (гучин долоон сая нэг зуун далан гурван мянга таван зуун наян)	-